

## ХООСОН БУЛШ

### 6.1 АРИУН СҮНС ЕСҮСИЙГ ҮХЛЭЭС АМИЛУУЛСАН

Янз бүрийн хариу үйлдэл нь өөр өөр үр дагавартай.

#### ОДОО УЙЛАХ БИШ БАЯРЛАХ ЦАГ

Долоо хоногийн эхний өдөр эрт харанхуй байхад Магдалын Мариа хадан булш уруу очиж, булшны амнаас хадыг зайлуулсан байхыг харав.<sup>2</sup>Тэгээд Мариа Симон Петр болон Есүсийн хайртай байсан нөгөө шавь уруу нь гүйн ирж -Тэд Эзэнийг булшнаас авчихжээ. Түүнийг тэд хаана тавьсныг бид мэдэхгүй гэж хэлэв.<sup>3</sup>Тиймээс Петр нөгөө шавийн хамт булш уруу гүйв.<sup>4</sup>Тэд хоёул хамтдаа гүйсэн боловч нөгөөдөх нь Петрээс хурдан гүйж, булшинд түрүүлэн ирээд<sup>5</sup>тонгойн хараад, даавуу байхыг л үзсэн боловч дотогш орсонгүй.<sup>6</sup>Араас нь Симон Петр ч гүйн ирэв. Тэр булш уруу орж, маалинган даавуу болон<sup>7</sup>толгойг нь ороосон даавууг л харав. Даавуунууд байсан байрандаа эвхээтэй байжээ.<sup>8</sup>Түрүүлэн ирсэн нөгөө шавь булшинд орж ирэн, хараад итгэв.<sup>9</sup>Учир нь Тэр үхэгсдээс амилах ёстой гэсэн Судрыг тэд ойлгоогүй л байлаа. (Иох 20:1-9 АБ 2004 )

<sup>17</sup>Би Түүнийг хармагцаа үхсэн хүн шиг хөлд нь уналаа. Тэр баруун мутраа над дээр тавьж -Бүү ай. Би бол эхэн ба эцэс бөгөөд<sup>18</sup>амьд Нэгэн мөн. Би үхсэн байсан. Харагтун, Би үеийн үед амьд байна. Надад үхэл ба Үхэгсдийн орны түлхүүр бий. (Илч 1:17-18 АБ 2004 )

[ ] Мари Бурханы Үгийг ойлгоогүйдээ уйлж байсныг та мэдэх үү?

[ ] Ариун Сүнсний хүч Есүсийг үхлээс амилуулсан бөгөөд Түүний

бие дахин хэзээ ч үхэхгүй гэдэгт та итгэдэг үү?

### 6.2 ЕСҮС МАГДАЛЫН МАРИАД ҮЗЭГДСЭН НЬ

<sup>10</sup>Ингээд шавь нар нь өөрсдийнхөн уруугаа буцав. <sup>11</sup>Харин Мариа булшны гадаа зогсоод уйлж байлаа. Тэр уйлсан чигээрээ булш уруу тонгойн харахад, <sup>12</sup>цагаан хувцастай хоёр тэнгэр элч Есүсийн цогцсыг тавьсан газарт нэг нь толгойн тэнд, нөгөө нь хөлөн талд нь сууж байв. <sup>13</sup>Тэд түүнд -Эмэгтэй, чи юунд уйлна вэ? гэсэнд тэр-Тэд Эзэнийг минь авчихсан байна. Тэд Түүнийг хаана тавьсныг би мэдэхгүй гэв. <sup>14</sup>Тэр ингэж хэлээд эргэхдээ Есүсийн зогсож байхыг харсан боловч тэр нь Есүс байсныг таньсангүй. <sup>15</sup>Есүс түүнд-Эмэгтэй, чи юунд уйлна вэ? Чи хэнийг хайна вэ? гэж асуув. Түүнийг цэцэрлэгч байна гэж бодоод тэр Түүнд -Эзэнтэн, хэрэв та Түүнийг авсан бол хаана тавьснаа надад хэлнэ үү? Би Түүнийг авах гэсэн юм гэв. <sup>16</sup>Гэтэл Есүс-Мариа гэлээ. Мариа эргэнгүүтээ Түүнд еврейгээр-Рабуни! (Багш гэсэн утгатай) гэжээ. <sup>17</sup>Есүс -Би дээшээ Эцэгтээ харахан очоогүй байгаа тул Надад гар бүү хүр. Харин Миний ах дүү нар уруу очиж, тэдэнд “Би Миний Эцэг ба та нарын Эцэгт, Миний Бурхан ба та нарын Бурханд очно” гэдгийг хэл гэлээ. <sup>18</sup>Магдалын Мариа ирж, шавь нарт -Би Эзэнийг харлаа гээд Есүсийн өөрт нь айлдсаныг тэдэнд хэлэв. (Иох 20:10-18 АБ 2004)

[ ] Амилсан Христийн найдвар бол Түүний хүүхдүүд үхлээс мөнх амь руу амилах болно гэдэгт та итгэдэг үү?

[ ] Амилалтын дараа илчлэгдсэн нууцыг та харж байна уу?

### 6.3 ЕСҮС ШАВЬ НАРТАА ҮЗЭГДСЭН НЬ

<sup>19</sup>Долоо хоногийн эхний өдөр буюу тэр өдрийн үдэш, шавь нар нь иудейчүүдээс айснаас хаалгаа түгжсэн байв. Гэтэл Есүс ирээд тэдний дунд зогсож, тэдэнд -Амар амгалан та нартай хамт байх болтугай гэв.

<sup>20</sup>Үүнийг айлдаад, Тэр тэдэнд гар, хажуугаа үзүүлэв. Шавь нар нь Эзэнийг хараад ихэд баярлав. <sup>21</sup>[Есүс] дахиж тэдэнд -Амар амгалан та нартай хамт байх болтугай.

Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ гэв. <sup>22</sup>Үүнийг айлдаад, Тэр тэдэн уруу үлээн -Ариун Сүнснийг хүлээн авагтун. <sup>23</sup>Та нар хэний нүглийг уучилна, тэд

уучлагдана. Та нар хэний нүглийг үл уучилна, тэд үл уучлагдах болно гэж айлдав. . (Иох 20:19-23 АБ 2004)

[ ] Та дэлхийгээс эмээдэг үү?

[ ] Та Их Эзэнээс эмээдэг үү?

[ ] Та зүрх сэтгэлдээ гашуун үндэс байлгадаг уу ?

#### 6.4 ЕСҮС ТОМАСТ ҮЗЭГДСЭН НЬ

<sup>24</sup>Харин арван хоёрын нэг болох ихэр гэгддэг Томас Есүсийг ирэх үед тэдэнтэй хамт байгаагүй ажээ. <sup>25</sup>Бусад шавь нар нь түүнд -Бид Эзэнийг харсан гэж ярив. Харин тэр -Түүний гар дахь хадаасны сорвийг үзэж, хадаасны ормонд нь хуруугаа хийн, Түүний хажуу уруу нь гараа хийж үзэхээс нааш би итгэхгүй гэж тэдэнд хэлжээ. <sup>26</sup>Найман өдрийн дараа шавь нар гэрт дахин цуглахад Томас тэдэнтэй хамт байв. Хаалга нь түгжээтэй байсан боловч Есүс ирээд тэдний дунд зогсож

-Амар амгалан та нартай хамт байх болтугай гэв. <sup>27</sup>Тэгээд Тэр Томаст -Хуруугаа нааш нь хүргэ, Миний гарыг үз. Гараа нааш нь хүргэ, Миний хажуу уруу хий. Итгэлгүй бус, харин итгэлтэй бай гэхэд <sup>28</sup>Томас Түүнд -Эзэн минь, Бурхан минь гэв. <sup>29</sup>Есүс түүнд -Чи Намайг харсан учраас итгэв үү? Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй еэ! гэжээ. <sup>30</sup>Мөн энэ номд бичээгүй өөр олон тэмдгийг Есүс [Өөрийн] шавь нарын өмнө үзүүлсэн юм. <sup>31</sup>Харин эдгээр нь Есүс бол Христ, Бурханы Хүү мөн гэдэгт та нарыг итгүүлэхийн тулд бичигдсэн бөгөөд ингэснээр итгэлээр дамжуулан та нар Түүний нэрээр амьтай болох юм. ( Иох 20:24-31 АБ 2004)

[ ] Зарим нь тохуурхан асууж, зарим нь итгэхийн тулд асуудаг.

Бурхан хүмүүсийн зүрх сэтгэл, санаа бодлыг шалгаж хандлагыг нь мэддэг учраас үүнийх нь дагуу хариулдаг байна. Та итгэхийн тулд асуудаг уу?

#### 6.5 ТА ХЭНТЭЙ АДИЛ ВЭ?

- Ариун Сүнсээр зүрх сэтгэлээ илчлүүлээрэй. Өнөөдөр амьд Бурхантай уулзаарай. Иохан 20-р бүлэг дээр дурдагсан хүмүүсээс та хэнтэй нь илүү адилхан байна вэ?

- Та амилсан Христтэй уулзсан уу эсвэл энэ нь зүгээр л нэг үлгэр домог уу?

- Хамгийн сайхан, хамгийн үнэ цэнэтэй гэнэтийн бэлэг Бурханы

Үгэн дотор хадгалагдсан гэдгийг та мэдэх үү ?

- Та Үгнээс юу олсон бэ?

- Бодол санаа чинь Бурханаас уу , эсвэл энэ дэлхийн бурхадаас уу гэдгийг хэрхэн ялгахаа мэдэх үү?

- Буруу замаар явахын үр дагаврыг та мэдэх үү?

## 6.6 БУРХАН БА ЕСҮС ХРИСТИЙН ҮГ

<sup>2</sup>Би Таны ариун сүм уруу хандан сөгдөн мөргөж, Таны хайр энэрэл, үнэний тань төлөө Таны нэрд талархал өргөнө. Учир нь Та Өөрийн бүх нэрээр Өөрийн үгийг өндөрт өргөмжилсөн юм. ( Дуу 138: 2 АБ 2004)

<sup>1</sup>Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. <sup>2</sup>Тэр эхэнд Бурхантай хамт байсан. <sup>3</sup>Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй. <sup>4</sup>Түүнд амь байсан бөгөөд амь нь хүмүүсийн гэрэл байв. <sup>5</sup>Гэрэл харанхуйг гийгүүлэхэд, харанхуй түүнийг дийлсэнгүй. ( Иох 1:1-5 АБ 2004)

<sup>53</sup>Есүс тэдэнд -Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй. <sup>54</sup>Миний махыг идэж, цусыг уусан хүн мөнх амьтай бөгөөд Би түүнийг эцсийн өдөрт амилуулна. <sup>55</sup>Учир нь Миний мах бол жинхэнэ хоол, Миний цус бол жинхэнэ ундаа мөн. <sup>56</sup>Миний махыг идэж, цусыг уусан хүн Миний дотор байж, Би ч түүний дотор оршин байна. <sup>57</sup>Амьд Эцэг маань Намайг илгээсэн бөгөөд Би Эцэгээр амьдрахын адил Намайг идэгч хүн мөн Надаар амьдарна. <sup>58</sup>Тэнгэрээс бууж ирсэн талх бол энэ мөн. Гэхдээ та нарын өвөг дээдэс идсэн, нас барсантай нь адилгүй, энэ

талхыг идсэн хүн мөнхөд амьдарна гэлээ. ( Иох 6:53-58 АБ 2004)

<sup>5</sup>Би бол усан үзмийн мод, та нар бол мөчрүүд. Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал, тэр хүн их жимс ургуулна. Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй. <sup>6</sup>Хэрэв хэн нэг нь Миний дотор байхгүй бол мөчир мэт хаягдаж, хувхайрна. Хүмүүс тэдгээр мөчрүүдийг түүж, галд хаяхад шатна. <sup>7</sup>Хэрэв та нар Миний дотор, Миний үгс та нарын дотор байвал та нар юу хүссэнээ гуй. Тэгвэл та нарын төлөө биелэх болно. <sup>8</sup>Та нарын их жимс ургуулснаар Эцэг минь алдаршуулагдана. Ийнхүү та нар Миний шавь нар байх болно. <sup>9</sup>Эцэг Намайг яаж хайрласан шиг Би бас та нарыг хайрласан. Миний хайр дотор байгтун. <sup>10</sup>Би Эцэгийнхээ тушаалыг сахиж, Түүний хайр дотор байдгийн адил, та нар Миний тушаалыг сахивал Миний хайр дотор байх болно. <sup>11</sup>Миний баяр баясгалан та нар дотор байж, та нарын баяр баясгалан нь дүүрэн болохын тулд энэ бүхнийг Би та нарт хэлэв. ( Иох 15:5-11 АБ 2004)

[ ] Та Бурханы Үгийг уншдаг уу?

[ ] Та Бурханы Үгийг харж байна уу?

[ ] Та Бурханы Үгийг иддэг үү?

[ ] Та Христийн цусыг уудаг уу? Энэ нь юу болохыг, хэрхэн гэдгийг та мэдэх үү?

[ ] Та Үгийг хэрхэн ууж, идэхийг мэдэх үү?

[ ] Дуулгаваргүй байх нь Бурханы эсрэг үйлдэл гэдгийг та мэдэх үү?

[ ] Дуулгаваргүй байдлын үр дагавар юу болохыг та мэдэх үү?

